

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
NATIONAL STATISTICAL OFFICE OF MONGOLIA



СТАТИСТИКИЙН БЮЛЛЕТЕНЬ
MONTHLY BULLETIN OF STATISTICS

5 сар
2009
May

Улаанбаатар хот
Ulaanbaatar

ГАРЧИГ CONTENTS

Ерөнхий тэмдэглэл <i>General notes</i>	3
Аргачлалын тайлбар <i>Methodological notes</i>	4
Товч танилцуулга <i>Introduction</i>	9
Үндсэн үзүүлэлтүүд <i>Main indicators</i>	15
I. Хөдөлмөр <i>Labour</i>	16
II. Эрүүл мэнд <i>Health</i>	20
III. Нийгмийн даатгал, нийгмийн халамж <i>Social insurance and social welfare</i>	23
IV. Гэмт хэрэг <i>Crime</i>	25
V. Өрхийн орлого, зарлагын судалгаа <i>Household income and expenditure survey</i>	29
VI. Үнэ <i>Price</i>	33
VII. Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл <i>Money, loan, stock market</i>	44
VIII. Улсын төсөв <i>State budget</i>	51
IX. Төлбөрийн тэнцэл <i>Balance of payments</i>	53
X. Гадаад худалдаа <i>External trade</i>	54
XI. Хөдөө аж ахуй <i>Agriculture</i>	64
XII. Аж үйлдвэр <i>Industry</i>	70
XIII. Их барилга <i>Constuction</i>	75
XIV. Тээвэр <i>Transport</i>	76
XV. Цаг уур, агаарын бохирдолт <i>Meteorology and air pollution</i>	77
Хавсралт <i>Appendix</i>	79

Ерөнхий тэмдэглэл**General notes****I. Товчилсон тэмдэглэгээ:**

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БХ	Баянхонгор
БУ	Булган
ГО	Говь-Алтай
ДО	Дорноговь
ДД	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
ДА	Дархан-Уул
УБ	Улаанбаатар
ОР	Орхон
ГС	Говьсүмбэр

I. Abbreviations:

AR	Arkhangai
BO	Bayan-Olgii
BKH	Bayankhongor
BU	Bulgan
GO	Govi-Altai
DO	Dornogovi
DD	Dornod
DU	Dundgovi
ZA	Zavkhan
OV	Ovorkhangai
OM	Omnogovi
SU	Sukhbaatar
SE	Selenge
TO	Tov
UV	Uvs
KHO	Khovd
KHS	Khovsgol
KHE	Khentii
DA	Darkhan-Uul
UB	Ulaanbaatar
OR	Orkhon
GS	Govisumber

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V... г.м)

I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.

1990-1995; 1990-1997 тухайн хугацааны жилийн дундаж үзүүлэлт болно.

III. Дараах тэмдэглэлүүдийг ашиглав:

- ... мэдээлэл байхгүй
- 0.0** маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй.

⎯⎯⎯ “Үүнээс” гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

II. Months have been shown by the Roman numerals (I, II, III, IV, V, etc).

I-XII shows the accumulated data from the beginning of the year including the particular month.

1990-1995; 1990-1997 annual average for this particular time period.

III. The following symbols were used:

- ... data are not available
- 0.0** the amount is nil or negligible
- no execution.

⎯⎯⎯ Shows the term “of which” and in some cases it indicates not all elements of sum are given.

IV. Due to the rounding figures (composition) may not add up to the total and 100 percentage.

Аргачлалын тайлбар**Methodological notes****Хөдөлмөр****Labour**

Ажиллагчдын тоо нь сарын эцэст бэлэн байгаа тухайн салбарын ажиллагчдын тоо юм. Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орсон.

The employment is the number of employees of the particular economic sector at the end of the month. According to the International standard methodology unemployed persons are those segments of the population in the working age who are currently not working in a paid or self-employed, actively looking for job and registered at the Employment Office.

Эрүүл мэнд**Health**

Нялхсын нас баралт (1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох)-ыг 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

The infant mortality rate (infants under age one year per 1000 live births) is estimated as a ratio of the number of deaths of infants under 1 year to the number of alive births during a particular period of time.

Гэмт хэрэг**Crime**

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нэлээд өөрчлөгдсөн.

The Crime indicators have been innovated and enriched in connection with change of Criminal Law.

-Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүй алах хэргийг нэгтгэн оруулсан.

- Indicators like crime against human life, health, crime to cause others to commit suicide, violent crime such as attempted and negligent murder are being compiled in the bulletin;

-Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

- Rape crime was included to the crime against children, family and social morality;

-Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

- Crime against ownership right includes theft of property, robbery, snatch away others property, deceiving to obtain others property, illegally misuse others property and wasting;

-Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
-Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

*- Arson was included to crime against environmental protection.
- Indecent assault was added to crime against social safety.*

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.

The number of committed offences per 10000 population aged 18 and over is a quotient of the number of crimes and number of people aged 18 and over at the beginning of the year.

Өрхийн орлого, зарлага

Үндэсний статистикийн байгууллага 1966 оноос эхлэн өрхийн орлого, зарлагын судалгааг явуулж байгаа бөгөөд одоогийн байдлаар жилд Монгол Улсын нийт өрхийг төлөөлөх 11232 өрхийг түүвэрлэн авч, тэдгээр өрхийн гишүүдийн нас, хүйс, ажил эрхлэлтийн байдал, өрхийн орлого, зарлага, хэрэглээний хэмжээ, сууцны нөхцлийн талаарх үзүүлэлтүүдийг хамруулан улирал бүр судалгаа явуулж байна.

Хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын үзүүлэлтүүдийг тооцох зорилгоор уг судалгааны арга зүйг (түүвэрлэлтийн зохиомж, судалгааны асуулгын үзүүлэлтүүд, загвар) 2005 оны 3 дугаар улирлаас эхлэн өөрчилсөн. Мөн өрхийн хэрэглээ, зардлын нэр төрлийг өргөжүүлэн олон улсын аргачлалаар “Хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангилал”-ын дагуу бүлэглэн бүртгэдэг болсон.

Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлагыг 2007 оны III улирлаас эхлэн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнгийн мэдээлэлд тулгуурлан тооцдог болсон тул аргачлал нь өмнөх судалгааныхаас өөрчлөгдсөн болно.

Household income and expenditure

Since 1966, the National Statistical Office has regularly conducted household income and expenditure survey. At present, a sample of 11232 households was selected annually to represent the total households of Mongolia and data on household member's age, sex, employment, household income, expenditure, consumption and housing condition are collected and analyzed on a quarterly bases.

The survey methodology (sample, questionnaire design and indicators) has been changed since the 3rd quarter of 2005 for estimating living standard and poverty indicators. Moreover the type of household consumption and expenditure was collected in accordance with international methodology as “COICOP”.

Since 3rd quarter of the year 2007, we have estimating average monthly income and expenditure of the household from result of Household socio-economic survey, hence its methodology had changed.

Үнэ

Аймгийн төв, нийслэлийн захуудад борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2005 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

Prices

The average market prices of agricultural foodstuff, wool, hide & skin at aimags centers & the capital city were shown.

The consumer price index is a weighted average by consumption expenditure distribution of prices of various goods and services purchased by the households for its own consumption.

Since January 2008 having revised its methodology for CPI by which CPI for Ulaanbaatar city was taken a national CPI, the National Statistics Committee has moved to the international methodology by which the national CPI is estimated on the basis of weighted average for 2005 HIES consumption expenditure of aimags and the Capital city.

Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөнд банкнаас гадуурх мөнгө, банкны касс дахь бэлэн мөнгийг оруулна.

Мөнгө M1-д улсын болон хувийн секторын харилцах дансан дахь мөнгө, иргэдийн хугацаагүй хадгаламж, банкны гадуурх бэлэн мөнгийг хамруулна.

Мөнгө M2 бол Мөнгө M1 болон бараг мөнгөний нийлбэр юм. Бараг мөнгөнд иргэд, байгууллагуудын хугацаатай хадгаламжууд, гадаад валютын хадгаламжийг хамруулна.

Үнэт цаасны тухайн сарын арилжаанд хамгийн их гүйлгээтэй байсан компанийн хувьцааг идэвхтэй хувьцаа гэж үздэг.

Монгол Улсын нэгдсэн төсөв

Төсвийн орлого, зарлагын тооцоог Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Сангийн яам, аймаг, нийслэлийн харъяа нэгжүүдээсээ авч нэгтгэн Үндэсний Статистикийн хороо (ҮСХ)-нд ирүүлдэг.

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын дүнд Засгийн газрын тусгай зориулалтын гэж нэрлэдэг Тэтгэврийн, Нийгмийн халамжийн, Замын, Өмч хувьчлалын сангуудын орлого, зарлагыг оруулсан.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл бол тайлант хугацааны туршид тухайн улс болон бусад улсын хооронд хийгдэж байгаа эдийн засгийн бүхий л үйл ажиллагааны үр дүнг тусган харуулна.

Үйлчилгээ нь тээвэр, аялал, харилцаа холбоо, барилгын ажил, даатгал, санхүү, компьютер мэдээллийн үйлчилгээ, патент, барааны тэмдэгтийн хураамж, лиценз, бусад бизнес, амралт соёлын ба Засгийн газрын үйлчилгээний нийлбэрээс бүрдэнэ.

Money, loan, stock market

Currency in circulation includes the population and commercial banks cash and currency outside the banks.

Money M1 includes public and private sector's bank account currency, population demand deposits and currency outside the banks.

Money M2 is a sum of money M1 and Quasi money. Quasi money consists of the time saving deposits of individuals and enterprises as well as foreign currency deposits.

An active stock in a particular month is considered as the stock of companies with predominated trading.

General government budget

Since October 1995, the budget revenue and expenditure has been compiled according to the International Monetary Fund standard classifications.

The Mongolian General government budget revenue and expenditure consists of the central and local budget revenue and expenditure.

The Ministry of Finance collect and aggregate the General government budget revenue and expenditure data from it's department and offices that are under the jurisdiction of the ministry and forward the data to the National Statistical Office (NSO).

State budget revenue and expenditure includes revenue and expenditure of Government Special funds for Pension, Social Security, Roads, and Privatization.

Balance of payments

The Balance of Payments is a statistical statement that systematically summarizes all economic transactions made between one particular country and the rest of the world during a specific time period.

Services covers transportation, travel, communication, construction, insurance, financial and computer, information services, royalties and license fees, other business services, personal, cultural and recreational services and government services.

Эдийн засгийн харъяат оршин суугчаас эдийн засгийн харъяат бус оршин суугчид үзүүлсэн үйлчилгээний орлогыг экспортод, харин эдийн засгийн харъяат оршин суугчаас эдийн засгийн харъяат бус оршин суугчид төлсөн үйлчилгээний зардлыг импортод бүртгэнэ. Үйлчилгээний орлого, зардлын зөрүүг тухайн үйлчилгээний цэвэр дүн гэж үзнэ.

Хөрөнгө ба санхүүгийн данс нь хөрөнгийн данс (хөрөнгийн эзэмшлийн өөрчлөлт), санхүүгийн данс (мөнгөн хөрөнгийн өөрчлөлт) гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Улсын валютын нөөц нь төрийн эрх бүхий байгууллага болон арилжааны банкны эзэмшилд байгаа гадаадын банк, санхүүгийн байгууллагад хадгалж байгаа мөнгөжсөн алт, чөлөөтэй хөрвөдөг гадаад валют, гадаадын үнэт цаасны зах зээл дээр чөлөөтэй борлогдох үнэт цаас болон бусад олон улсын хэмжээнд валютын нөөцөд тооцогдох үнэт зүйлээс бүрдэнэ.

ҮСХ-ны дарга, Сангийн сайд, Гаалийн Ерөнхий Газрын даргын 2009 оны 2 дугаар сарын 17 өдрийн хамтарсан тушаалаар “Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг шинэчлэн баталж мөрдөж байна. Төлбөрийн тэнцлийн бүрэлдэхүүн хэсэг болох бараа, үйлчилгээний тэнцлийг энэхүү аргачлалын дагуу нэгтгэж байна. Бараа, үйлчилгээний өмнөх оны гүйцэтгэлийг уг аргачлалын дагуу тооцсон болно.

Гадаад худалдаа

ҮСХ-ны дарга, Сангийн сайд, Гаалийн Ерөнхий Газрын даргын 2009 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хамтарсан тушаалаар “Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг шинэчлэн баталж мөрдүүлсэн. Шинэчлэгдсэн аргачлалын дагуу гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг тооцож байна. Мөн өмнөх оны гүйцэтгэлүүдийг шинэчилсэн аргачлалын дагуу тооцлоо.

Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын статистикийн мэдээг үндэслэн тус бүлгийн хүснэгтүүдийг боловсруулав.

Дэлхийн худалдааны байгууллагаас боловсруулсан “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-

Receipts of the services from residents to non residents are treated in exports and payments from residents to non residents are treated in imports. Difference between receipts and payments are viewed net receipts.

The capital and financial account of the balance of payments is divided into two main categories: the capital account (changes in acquisition of capital assets) and the financial account (changes of ownership in financial assets and liabilities).

Reserve assets consist of those external assets that are readily available to and controlled by monetary authorities for direct financing of payments imbalances, for indirectly regulating the magnitude of such imbalances through intervention in exchange markets to affect the currency exchange rate, and/or for other purposes.

“The Methodology for estimating indicators of merchandise trade statistics” was revised and approved by a joint Resolution of February 17, 2009 by Chairman of the NSO, Finance Minister and Director of Customs General Administration. According to the revised methodology, data on goods and services for the balance of payments has been aggregated and related estimates for previous years has been adjusted.

External trade

On 17th February of 2009, the chairman of NSO, the Minister of Finance and the director of Customs General Administration approved “Methodology of calculating indicators of merchandise trade statistics”. According to this new methodology and its amendments, estimates of previous years have changed.

The table of this chapter were developed on the basis of the statistical reports from the Customs General Administration of Mongolia.

The commodities were classified according to the Harmonized System developed by the World Trade Organization.

ийн ангиллын дагуу барааны бүлэг, нэр төрлийг авсан болно. С.И.Ф нөхцлийн үнээр импортын барааг үнэлэх бөгөөд энэ нь худалдан авагч орны хил хүртэлх тээвэр болон даатгалын, гаалийн хураамж зэрэг зардлуудыг экспортлогч хариуцна гэсэн үг.

The price of import goods is defined by the CIF condition which means that exporter has to bear costs of transportation and insurance till purchaser's country border as well as customs tax.

Аж үйлдвэр

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Industry

Classification by the kind of economic activities is based on the ISIC (International Standard Industrial Classification) of United Nation.

The value of total industrial sale is value of sales, completed work and services of business entities during the particular period.

The growth of the industrial production was estimated on the basis of constant price of 2005 for the main commodities.

Data on production of the main industrial commodities shows a physical quantity of the particular produced goods.

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол, гамшгийн хувьд “Гамшгаас хамгаалах тухай” Монгол улсын хуульд заасан ойлголт, тодорхойлолтыг баримталж байна.

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно.

Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Hazardous phenomena and disasters

For terms, namely hazardous phenomena, disasters, and accidents, concepts and definitions set out in the Law on Disaster Protection of Mongolia are followed.

Disasters mean loss of many human lives and livestock, immense damage to property and environment that exceeds national and local resources and capacity due to hazardous phenomena, major technological accidents, and terrorist acts or explosion.

Hazardous phenomena mean severe snow, dust storm, drought, dzud, flood, earthquake, desertification, fire, epidemic, epizootic, hazardous vegetative diseases or spreading detrimental rodents.

Major technological accidents mean destruction of factories, buildings, communication or roads, accidents of transportation facilities or leakage of radioactive and hazardous chemical substances caused by violation of technological procedures.

**Монгол улсын нийгэм,
эдийн засгийн байдал
(2009 оны эхний 5 сарын байдлаар)**

**Social and economic situation
of Mongolia
(In the first 5 months of 2009)**

I. Нийгмийн үзүүлэлт

Улсын хэмжээгээр төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 2009 оны эхний 5 сарын байдлаар 27 808 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2723 хүүхдээр, амаржсан эх 27 727 болж, 2733 эхээр буюу 10.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 595 болж, өмнөх оны мөн үеийнхээс 56 хүүхдээр, эхийн эндэгдэл 23 болж, 15 эхээр тус тус нэмэгдэж, харин 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 80 болж, 27 хүүхдээр буурчээ.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээр нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2009 оны 1 дүгээр улирлын байдлаар 344.7 мян.төг болж өмнөх оны мөн үеийнхээс 60.7 мян.төг буюу 21.4 хувиар нэмэгдлээ. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2009 оны 1 дүгээр улирлын байдлаар 355.7 мян.төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 30.7 мян.төг буюу 9.5 хувиар өссөн байна.

Аймаг, нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс (ХХҮХ)-т бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйдүүдийн тоо 2009 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар 38.8 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 6571 хүн буюу 20.4 хувиар нэмэгдсэн байна. Үүнд Баян-Өлгий, Говь-Алтай, Сэлэнгэ аймгийн бүртгэлтэй ажилгүйдүүдийн тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.1-32.6 хувиар буурсан бол Увс, Хэнтий, Төв Булган аймаг болон Улаанбаатар хотод 30.9-85.5 хувь, Өмнөговь аймагт 2 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 16.1 мянга болж, өмнөх оны мөн

I. Social indicators

In the first 5 months of 2009, the number of births (live birth) reached 27 808, an increase of 2723 compared to the same period of the previous year national level, while the number of mothers delivered children was 27 727, an increase of 2733, or an increase of 10.9 percent compared with the same period of the previous year.

Compared with the same period of the previous year, the number of under-one infant mortality rose to 595 or by 56 infants and the number of maternal deaths increased to 23 or by 15, whereas the number of mortality of children aged between 1-5 years fell to 80 or by 27 children.

According to a report of the 1st quarter of 2009 a of the Household Socio-Economic Survey, monthly average household monetary income was 344.7 thous.togrogs, an increase of 60.7 thous.togrogs, or by 21.4 percent, compared to the same period of the previous year. Monthly household monetary expenditure was 355.7 thous.togrogs, an increase of 30.7 thous.togrogs, or by 9.5 percent, compared to the same period of the previous year.

At the end of May 2009, the number of unemployed who had registered themselves at Labour and Welfare Service Divisions in aimags and the capital city and were actively looking for job reached 38.8 thous, an increase of 6 571 or by 20.4 percent compared with the same period of the previous year. Compared with the same period of the preceding year, 3.1-32.6 percent decrease of registered unemployed in some aimags, namely Bayan-Ulgii, Govi-Altai, and Selenge and 30.9-85.5 percent increase in some aimags, namely Uvs, Khentii, Tuv, Bulgan, and Ulaanbaatar city, and 2.0 times increase in Umnugovi aimag had mainly contributed to this increase.

Compared with the same period of the previous year, cases of shigellosis increased

үеийнхээс 1252 хүн буюу 7.2 хувиар буурахад цусан суулгаар өвчлөгчдийн тоо 62.7 хувь, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 34.8 хувь, гоноккокт халдвараар өвчлөгчдийн тоо 23.1 хувиар тус тус өссөн хэдий ч вируст гепатитаар өвчлөгчдийн тоо 47.8 хувь, салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 15.5 хувиар тус тус буурсан нь нөлөөллөө.

Улсын хэмжээнд 2009 эхний 5 сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 9 077 болж өмнөх оны мөн үеийнхээс 417 хэргээр буюу 4.8 хувиар өсчээ. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеийнхээс өсөхөд бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, залилан дээрэмдэх, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, бусдын бие махбодид гэмтэл учруулах, бусдыг амиа хорлоход хүргэх зэрэг хэргүүд 4.0-37.4 хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

II. Макро эдийн засгийн үзүүлэлт

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮҮИ) 2009 оны 5 дугаар сард өмнөх сарынхтай харьцуулахад 0.1 хувь, өмнөх оны жилийн эцсийнхээс 5.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 8.0 хувиар өссөн байна.

Тээврийн бүлгийн дүн 3.7 хувиар буурч, согтууруулах ундаа, тамхины бүлгийн дүн 2.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн дүн 3.3 хувь, бусад бараа үйлчилгээний бүлгийн дүн 1.8 хувиар өмнөх сарынхаас өссөн нь хэрэглээний үнийн улсын индекс 2009 оны 5 дугаар сард өмнөх сарынхтай харьцуулахад 0.1 хувиар өсөхөд голлон нөлөөлөв.

Монгол банкны мэдээгээр мөнгөний нийлүүлэлт (M2) 2009 оны 5 дугаар сарын эцэст 2461.4 тэрбум төгрөг болж өмнөх сарынхаас 60.8 тэрбум төгрөг буюу 2.5 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 55.2 тэрбум төгрөг буюу 2.2 хувиар буурав. Мөнгөний нийлүүлэлт оны эхнээс 142.5 тэрбум төгрөг буюу 6.1 хувиар нэмэгдэхэд бараг мөнгөний өсөлт голлон нөлөөлжээ.

by 62.7 percent, syphilis by 34.8 percent, and gonococcal infection by 23.1 percent, while hepatitis decreased by 47.8 percent and varicella by 15.5 percent, which resulted in a fall of 16.1 thous, a decrease of 1252 or 7.2 percent in the number of persons with infectious diseases.

The total number of crimes committed in the first 5 months of 2009 was 9 077, reflecting an increase of 417 crimes, or an increase of 4.8 percent compared with the same period of the previous year. The increase in the number of crimes recorded at the Police Office was due to 4.0-37.4 percent increase in crimes such as forgery, fraud, robbery, crime against environmental protection, bodily aggravated crimes, and death due to unfortunate occasion.

II. Macro economical indicators

The national consumer price index in May 2009 was up by 0.1 percent compared with the previous month, reflecting 5.7 percent increase compared to the end of previous year and a 8.0 percent increase over the same month last year.

The price of transport group decreased by 3.7 percent, whereas alcoholic beverage, tobacco group rose by 2.1 percent, health group by 3.3, and miscellaneous goods & services by 1.8 over the previous month, which resulted in the 0.1 percent increase in the overall index compared to the previous month.

According to the report of the Bank of Mongolia, money supply (broad money or M2) at the end of May 2009, expanded to 2461.4 bln.togrogs, which reflects an increase of 60.8 bln.togrogs or 2.5 percent, over April 2009 and a decrease of 55.2 bln.togrogs, or 2.2 percent, compared to May 2008. Growth of quasi money is the main factor of an increase of 142.5 bln.togrogs or 6.1 percent in money supply from the beginning of 2009.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2009 оны 5 дугаар сарын эцэст 384.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сарынхаас 29.0 тэрбум төгрөг буюу 8.1 хувиар, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 11.0 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар тус тус нэмэгдлээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2009 оны 5 дугаар сарын эцэст 2548.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сарынхаас 32.0 тэрбум төгрөг буюу 1.2 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 60.7 тэрбум төгрөг буюу 2.4 хувиар өслөө.

Үнэт цаасны арилжаа 2009 оны 5 дугаар сард 21 удаа явагдаж, 6.8 сая ширхэг үнэт цаас арилжигдаж, 2.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийжээ.

Арилжаалсан үнэт цаасны тоог өмнөх сарынхтай харьцуулбал 8.8 сая ширхэг буюу 56.3 хувь, гүйлгээний хэмжээ нь 5.6 сая төгрөг буюу 0.3 хувиар буурсан ба өмнөх оны мөн үеийнхээс арилжаалсан үнэт цаасны тоо 48.8 сая ширхэг буюу 87.7 хувиар, гүйлгээний хэмжээ 23.6 тэрбум төгрөг буюу 91.6 хувиар буурчээ.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2009 оны эхний 5 сард 633.1 тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 824.9 тэрбум төгрөг болж, нийт тэнцэл 191.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 199.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд төсвийн зарлагын өсөлт, орлогынхоос 24.3 пунктээр өндөр байгаа нь нөлөөлөв.

Төсвийн урсгал орлого 632.2 тэрбум төгрөг, урсгал зардал 702.4 тэрбум төгрөг болж, урсгал тэнцэл 70.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 212.4 тэрбум төгрөг буюу 29.8 хувиар буурахад зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар 124.3 тэрбум төгрөг буюу 86.9 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 54.7 тэрбум төгрөг буюу 45.5 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 9.0

At the end of May 2009, currency issued in circulation reached 384.6 bln.togrogs demonstrating an increase of 29.0 bln.togrogs, or 8.1 percent, compared to April 2009, and an increase of 11.0 bln.togrogs, or 2.9 percent compared to May 2008.

Remainder of loans outstanding at the end of May 2009, amounted to 2548.3 bln.togrogs, a decrease of 32.0 bln.togrogs, or 1.2 percent, over the April 2009, and an increase of 60.7 bln.togrogs, or 2.4 percent, compared to May 2008.

In May of 2009, there were 21 trading days and 6.8 mln.shares valued at 2.2 bln.togrogs were traded.

Compared with April 2009, the number of shares traded decreased by 8.8 mln.stocks or 56.3 percent and the value of traded shares by 5.6 mln.togrogs or 0.3 percent. Compared to May 2008, the number of shares traded decreased by 48.8 mln.stocks or 87.7 percent and value of traded stocks by 23.6 bln.togrogs or 91.6 percent respectively.

Total revenue and grants of General Government budget amounted to 633.1 bln.togrogs and total expenditure and net lending was 824.9 bln.togrogs representing a deficit of 191.8 bln.togrogs in the General Government budget overall balance. The higher deficit of 199.4 bln.togrogs against the same period of the previous year was due to Government expenditure growth which was 24.3 point higher than the total revenue growth.

Current revenue of General Government amounted to 632.2 bln.togrogs and current expenditure reached 702.4 bln.togrogs. Thus, the budget current balance was in deficit of 70.2 bln.togrogs.

Compared with the same period of the previous year, tax revenue declined by 212.4 bln.togrogs or 29.8 percent. This was mainly due to decreases of 124.3 bln.togrogs or 86.9 percent in price increase tax of some products, of 54.7 bln.togrogs or 45.5 percent

тэрбум төгрөг буюу 7.4 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад хувьцааны ногдол ашгийн орлого 41.4 тэрбум төг, навигагийн орлого 9.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн боловч газрын тосны орлого 11.2 тэрбум төг, төсөвт газрын өөрийн орлого 7.9 тэрбум төг, бусад нэр заагдаагүй орлого 5.5 тэрбум төгрөгөөр буурснаас шалтгаалж татварын бус орлого 27.8 тэрбум төгрөгөөр өслөө.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2009 оны эхний 5 сард 824.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 11.9 тэрбум төг буюу 1.5 хувиар өсчээ. Үүнд цалин, хөлсний зардал 17.4 тэрбум төгрөг буюу 8.2 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хөрөнгийн зардалд 2009 оны эхний 5 сард 77.2 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 4.6 тэрбум төгрөг буюу 5.7 хувиар буурсан байна. Хөрөнгийн зардал буурсан нь дотоодын эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгө оруулалт 13.3 тэрбум төгрөг буюу 16.5 хувиар багассанаас шалтгаалжээ.

Манай улс 2009 оны эхний 5 сард дэлхийн 90 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 1287.0 сая ам.доллар, үүнээс экспорт 592.9 сая ам.доллар, импорт 694.1 сая ам.доллар боллоо.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 858.8 сая ам.доллар буюу 40.0 хувь, үүний дотор экспортын хэмжээ 403.3 сая ам.доллар буюу 40.5 хувь, импортын хэмжээ 455.5 сая ам.доллар буюу 39.6 хувиар тус тус буурчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2009 оны эхний 5 сард 101.2 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 52.2 сая ам.доллараар буурсан байна.

Нийт экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 403.3 сая ам.доллар буюу 40.5 хувиар буурсны 334.6 сая ам.доллар буюу 83.0 хувь нь үнийн бууралтаас, 68.7 сая ам.доллар буюу 17.0 хувь нь биет хэмжээний бууралтаас шалтгаалсан байна.

in corporate income tax, of 9.0 bln.togrogs or 7.4 percent in value added tax.

Compared with the same month of the preceding year, non-tax revenue increased by 27.8 bln.togrogs, out of which dividends was up by 41.4 bln.togrogs and revenue from navigation by 9.3 bln.togrogs while revenue from crude oil was down by 11.2 bln.togrogs, own earnings of state-owned organizations by 7.9 bln.togrogs, and other revenues by 5.5 bln.togrogs.

Compared with the same period of the previous year, total expenditure and net lending of the General Government budget reached 824.9 bln.togrogs reflecting an increase of 11.9 bln.togrogs and 1.5 percent. This was mainly due to a rise of 17.4 bln.togrogs, or 8.2 percent, in wages and salaries.

Spending of 77.2 bln.togrogs on capital expenditure in the first 5 months of 2009 was lower by 4.6 bln.togrogs, or 5.7 percent over the same period of last year. Decrease in capital expenditure was due to a decline of 13.3 bln.togrogs, or 16.5 percent in domestic investment of internal sources.

In the first 5 months of 2009, Mongolia traded with 90 countries from all over the world and total external trade turnover reached 1287.0 mln.US dollars, of which exports made up 592.9 mln.US dollars and import did 694.1 mln.US dollars.

Compared with the same period of the previous year, total external trade turnover declined by 858.8 mln.US dollars, or 40.0 percent, of which exports by 403.3 mln.US dollars, or 40.5 percent, imports by 455.5 mln.US dollars, or 39.6 percent respectively.

External trade balance in the first 5 months of 2009, showed a deficit of 101.2 mln.US dollar, a 52.2 mln.US dollar decrease compared with the same period of the previous year.

Compared with the same period of the previous year, total export decreased by 40.5 percent or 403.3 mln.US dollars of which 83.0 percent or 334.6 mln. US dollar was due to value decrease and 17.0 percent or 68.7 mln. US dollars was owing to volume decrease.

Нийт экспортын хэмжээ буурахад зэсийн баяжмалын биет хэмжээ 1.3 хувь, үнийн дүн 58.7 хувь, цайрын баяжмалын биет хэмжээ 38.3 хувь, үнийн дүн 68.7 хувь, боловсруулаагүй алтны биет хэмжээ 27.0 хувь, үнийн дүн нь 29.9 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлөв.

Нийт импортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 455.5 сая ам.доллар буюу 39.6 хувиар буурсны 52.7 сая ам.доллар буюу 11.6 хувь нь үнийн бууралтаас, 402.8 сая ам.доллар буюу 88.4 хувь нь биет хэмжээний бууралтаас шалтгаалсан байна.

III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт

Улсын хэмжээнд 2009 онд нийт 18.5 сая эх мал төллөнө. 2009 оны эхний 5 сарын байдлаар 13.4 сая эх мал буюу төллөх эх малын 72.2 хувь нь төллөсөн байна.

Улсын хэмжээгээр энэ оны эхний 5 сарын байдлаар 1033.1 мянган том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеийнхээс 124.1 мянгаар буюу 10.7 хувиар буурчээ.

Улсын хэмжээнд энэ оны 6 дугаар сарын 1-ний байдлаар 243.3 мян.га талбайд тариалалт хийснээс үр тариа 227.5 мян.га-д, төмс 10.8 мян.га-д, хүнсний ногоо 3.6 мян.га-д, тэжээлийн ургамал 1.1 мян.га-д, техникийн ургамал 0.3 мян.га-д тус тус тариалаад байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 2009 оны эхний 5 сарын байдлаар 2005 оны зэрэгцүүлэх үнээр 615.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 47.9 тэрбум төгрөгөөр буюу 7.2 хувиар буурлаа. Үүнд: уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт 5.3 тэрбум төгрөгөөр буюу 1.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбар 44.9 тэрбум төгрөгөөр буюу 21.8 хувиар буурсан нь нөлөөлөв.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеийнхээс 1.5 хувиар буурахад 35 хувийн агуулгад шилжүүлснээр зэсийн баяжмал,

Compared with the same period of the previous year, total export fell due to declines of 1.3 percent in the volume and 58.7 percent in value of copper concentrate and 38.3 percent in volume and 68.7 percent in value of zinc concentrate, and of 27.0 percent in volume and 29.9 percent in value of gold, in unwrought or semi-manufactured forms, respectively.

Compared with the same period of the previous year, total import decreased by 39.6 percent or 455.5 mln. Us dollars of which 11.6 percent or 52.7 mln. US dollar was due to value decrease and 88.4 percent or 402.8 mln. US dollars was owing to volume decrease.

III. Economical sector indicators

In 2009, a total of 18.5 mln. breeding stock will give birth at the national level. In first 5 months of 2009, 13.4 mln. breeding stock, or 72.2 percent of total breeding stock, gave birth.

As of the first 5 months of 2009, 1033.1 thousand adult animals lost. It decreased by 124.1 thous.heads or 10.7 percent compared with the same period of the previous year.

As of the 1st June of 2009, there are 243.3 thous.hectares of sown area, which consists of 227.5 thous.hectares of cereals, 10.8 thous.hectares of potatoes, 3.6 thous.hectares of vegetables, 1.1 thous.hectares of fodder crops, and 0.3 thous.hectares of technical crops.

In the first 5 months of 2009, the total industrial output reached 615.4 bln.togrogs demonstrating a decrease of 7.2 percent or by 47.9 bln.togrogs (at 2005 constant prices), compared with the same period of pervious year. The fall in the industrial output was due to an decrease of 5.3 bln.togrogs or 1.5 percent in mining and quarrying sector output and 44.9 bln.togrogs or 21.8 percent in manufacturing sector output.

Compared with the same period of the previous year, 1.5 percent decrease in output of the mining and quarrying sector was mainly due to the 1.6-42.8 percent reduction in output of main mining products such as

цайрын баяжмал, хайлуур жоншны баяжмал, алт, гянтболдын баяжмал зэрэг уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.6-42.8 хувиар буурсан нь нөлөөлжээ.

Харин боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн 21.8 хувийн бууралтад пиво, бетон дэр, катодын зэс, шохой, тамхи, самнасан ноолуур, дээд гурил, дарс, металл бэлдэц, цувимал, спирт, хивс, цул бетон, бетон зуурмаг, төмөр бетон эдлэл, молибдений исэл зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл 11.1-83.6 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Улсын хэмжээнд 2009 оны эхний 5 сард нийт 35.9 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэснээс 33.3 тэрбум төгрөг буюу 92.7 хувийг дотоодын барилгын байгууллагууд, 2.6 тэрбум төгрөг буюу 7.3 хувийг гадаадын барилгын байгууллагууд гүйцэтгэсэн байна.

Төмөр замын тээврээр 2009 оны эхний 5 сард 5467.2 мян.т ачаа, давхардсан тоогоор 1266.6 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 653.7 мян.т буюу 10.7 хувь, зорчигчдын тоо 514.9 мян.хүн буюу 28.9 хувиар буурчээ.

Агаарын тээврээр 2009 оны эхний 5 сард 410.2 тонн ачаа, давхардсан тоогоор 87.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 375.8 тонн буюу 47.8 хувь, зорчигчдын тоо 41.4 мян.хүн буюу 32.0 хувиар тус тус буурчээ.

copper concentrate, gold, fluor spar concentrate, tungsten concentrate and zincum concentrate.

At the same time, 21.8 percent decrease in output of manufacturing sector was mainly due to the 11.1-83.6 percent reduction in output of products such as beer, metal sleeper, copper, lime, combed down, wheat flour, metal steel, metal foundries, spirit, carpet, solid concentrate, concentrate mortar, articles of iron concrete, and molybdenum concentrate.

As of the first 5 months of 2009, construction and installation work worth 35.9 bln.togrogs were carried out. Of which 33.3 bln.togrogs, or 92.7 percent, were executed by domestic entities, and 2.6 bln.togrogs, or 7.3 percent, by foreign entities.

In the first 5 months of 2009, 5467.2 thous.ton freight and 1266.6 thous.passenger (with double count) were carried by railway transport. Compared with the same period of the previous year, carried freight fell by 10.7 percent, or 653.7 thous.ton, and carried passengers decreased by 28.9 percent, or 514.9 thous.persons.

In the first 5 months of 2009, 410.2 ton freight and 87.9 thous.passenger (with double count) were carried by air transport. Compared with the same period of the previous year, carried freight fell by 47.8 percent, or 375.8 ton, and carried passengers decreased by 32.0 percent, or 41.4 thous.persons, respectively.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

CHAIRMAN OF THE NATIONAL STATISTICAL
OFFICE OF MONGOLIA

С.МЭНДСАЙХАН

S.MENDSAIKHAN

2009 оны 6-р сарын 9
9 June 2009

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 5 сарын байдлаар
MAIN INDICATORS, in May of selected years

		2008 I-V	2009 I-V	2009 I-V 2008 I-V	%
Нийгмийн статистикийн үзүүлэлт	Social statistical indicators				
Төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлт)	Number births (live births)	25 085	27 808	110.9	
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, 5 дугаар сарын эцэст, мян.хүн	Unemployment, end of the May, thous.persons	32 225	38 796	120.4	
Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо	Number of infectious disease cases	17 399	16 147	92.8	
Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	Number of committed offences	8 660	9 077	104.8	
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт	Macro economic statistical indicators				
Хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт, оны эхнээс, хувиар	National consumer price index, percent, from the beginning of the year	19.5	5.7	-	
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө*, 5 дугаар сарын эцэст, тэрбум төг	Currency in circulation* end of the May, bln.tog	373.6	384.6**	102.9	
Мөнгө M1* 5 дугаар сарын эцэст, тэрбум төг	Money M1* end of the May, bln.tog	620.6	584.3**	94.2	
Мөнгө M2* 5 дугаар сарын эцэст, тэрбум төг	Money M2* end of the May, bln.tog	2 516.6	2461.4**	97.8	
Валютын зах зээлийн ханш, 5 дугаар сарын эцэст, 1 ам.доллар=төгрөг*	Market exchange rate, end of the May 1 USD=togrog*	1 161.4	1 428.4	123.0	
Улсын нэгдсэн төсвийн орлого, оны үнээр, тэрбум төг	Revenue of General Government, at current price, bln.tog	820.6	633.1	77.2	
Улсын нэгдсэн төсвийн зарлага, оны үнээр, тэрбум төг	Expenditure of General Government, at current price, bln.tog	813.0	824.9	101.5	
Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцэл, тэрбум төг	General Government budget overall balance, bln.tog	7.6	-191.8	-	
Улсын нэгдсэн төсвийн урсгал орлого, оны үнээр, тэрбум төг	General Government current budget revenue, at current price, bln.tog	816.8	632.2	77.4	
Улсын нэгдсэн төсвийн урсгал зарлага, оны үнээр, тэрбум төг	General Government current budget expenditure, at current price, bln.tog	683.6	702.4	102.7	
Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл, тэрбум төг	General Government budget current balance, bln.tog	133.2	-70.2	-	
Экспорт, сая ам.долл	Exports, mln.USD	996.2	592.9	59.5	
Импорт, сая ам.долл	Imports, mln.USD	1 149.6	694.1	60.4	
Гадаад худалдааны тэнцэл, сая ам.долл	External trade balance, mln.USD	- 153.4	- 101.2	65.9	
Эдийн засгийн статистикийн үзүүлэлт	Economic statistical indicators				
Бойжсон төл, мян.тол	Number of survivals, thous.heads	11 411.6	12 487.0	109.4	
Хорогдсон том мал, мян.тол	Losses of adult animals, thous.heads	1 157.2	1 033.1	89.3	
Тариалсан талбай, жил бүрийн 6 дугаар сарын 1-ний байдлаар, га	Sown areas, on the 1st of June of selected years, hectar	146 839.6	243 348.0	165.7	
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг	Gross industrial output, at constant prices of 2005, bln.tog	663.3	615.4	92.8	
Үүнээс:	Of which:				
-Уул уурхай, олборлох үйлдвэр	-Mining and quarrying	367.3	361.9	98.5	
-Боловсруулах аж үйлдвэр	-Manufacturing	205.5	160.6	78.2	
-Цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамж	-Electricity, thermal energy and water supply	90.5	92.9	102.6	
Төмөр замын тээврээр тээсэн ачаа мян.т	Carried freight by railway transport, thous.t	6 120.9	5 467.2	89.3	
Төмөр замын тээврээр тээсэн зорчигчид, мян.хүн	Carried passengers by railway transport, thous.persons	1 781.5	1 266.6	71.1	
Агаарын тээврээр тээсэн ачаа, т	Carried freight by air transport, t	786.0	410.2	52.2	
Агаарын тээврээр тээсэн зорчигчид, мян.хүн	Carried passengers by air transport, thous.persons	129.3	87.9	68.0	

* Эх сурвалж: Монгол банкны статистикийн сарын мэдээлэл

* Source: Monthly statistical bulletin, Bank of Mongolia

** Тайлбар: Урьдчилсан гүйцэтгэлээр

I. ХӨДӨЛМӨР
LABOUR

1.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ТОО, салбараар, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар
EMPLOYMENT IN INDUSTRY, by divisions, by the end of May of the selected years

Аж үйлдвэрийн салбар	Industrial division	2008 V	2009 V	2009 V 2008 V
Аж үйлдвэрийн салбар	Industrial division	49 510	47 164	95.3
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	Mining and quarrying	14 626	13 727	93.9
Нүүрс олборлолт	Mining of coal and lignite, extraction of peat	3 234	3 271	101.1
Газрын тос, шатдаг хий олборлолт	Extraction of crude petroleum and natural gas	74	74	100.0
